




МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО



**“Аж ахуйн нэгжийн үйл
ажиллагаанд Корона вирус
(Covid-19)-ээс урьдчилан
сэргийлэх, хөл хорио тогтоох
арга хэмжээний нөлөөлөл”**

Улаанбаатар хот
2020 он

ОРШИЛ

Шинэ төрлийн Корона вирусний (Covid-19) халдвар анх 2020 оны 1-р сард БНХАУ-ын Хубэй мужийн Ухань хотод бүртгэгдсэнээс хойш эхний давлагаа Ази тивд тэр дундаа БНХАУ, БНСУ, Япон, Иран улсуудад эрчимтэй тархаж байсан бол 3-р сарын сүүл, 4-р сараас эхлэн Европ болон Америкт тивд эрчимтэй тархаж, халдварын тохиолдол нэмэгдсээр байна.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас улс орнуудад тус халдвараас урьдчилан сэргийлэх талаар бүх талын заавар, зөвлөмж, чиглэлийг өгөхөөс гадна эрүүл мэндийн хангамж, тусламж, үйлчилгээг үзүүлсээр байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 1-р сарын 27-ны өдрийн 30 дугаар тогтоолоор үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан бүх шатны сургууль, цэцэрлэг, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагууд, номын сан, кино театр зэрэг соёл урлаг, үзвэр үйлчилгээний газрууд, бүх төрлийн спортын уралдаан тэмцээн зохион байгуулах газрууд, интернэт, цахим тоглоомын газрууд болон хүн олноор цуглардаг бусад газруудын үйл ажиллагааг 3-р сарын 2-ныг хүртэлх хугацаагаар түр зогсоох эхний шийдвэрийг гаргасан билээ.

Манай улсад шинэ төрлийн Корона вируст (Covid-19) халдварын анхны тохиолдол 3-р сарын 10-ны өдөр бүртгэгдсэн бөгөөд одоогоор нас барсан тохиолдол бүртгэгдээгүй байна.

Дэлхий даяар Корона вирусний (Covid-19) халдвар эрчимтэй тархсанаар Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 2-р сарын 19-ний өдрийн хуралдаанаар “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлсэн хугацааг 3-р сарын 30-ныг хүртэл, 3-р сарын 22-ны өдрийн хуралдаанаар 4-р сарын 30-ныг хүртэл, 4-р сарын 29-ний өдрийн хуралдаанаар 5-р сарын 31-нийг дуустал, 5-р сарын 29-ний өдрийн хуралдаанаар энэ хугацааг дахин 6-р сарын 30-ны өдрийг дуустал хугацаагаар нийт 4 удаа сунгасан бөгөөд хилийн боомтууд болон агаарын тээврийн үйлчилгээг хязгаарлах, хөл хорио тогтоох, үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааг хязгаарлах болсноор аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа болон өрх, хүн амын амьдралд нэлээд өөрчлөлт гарч байна.

Үндэсний Статистикийн Хорооноос энэ оны 4-р сарын 1-нээс 5-р сарын 20-ны өдрүүдэд нээлттэй байдлаар буюу онлайнаар “Covid-19” халдварт өвчний эсрэг авч буй урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээ нь аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа болон өрх, хүмүүсийн амьдралд хэрхэн нөлөөлж, ямар өөрчлөлт гарч байгааг тандах зорилгоор энэхүү судалгааг зохион байгууллаа.

Статистикийн бизнес регистрийн санд 2020 оны эхний улирлын байдлаар 94 675 ААН үйл ажиллагаа явуулж байгаагийн хамгийн өндөр буюу 37 382 (39.5%) нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж байна. Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн тоог эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллаар (Хүснэгт 1) харуулав.

Хүснэгт 1. Үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо, салбарын ангиллаар, 2020 оны эхний улирлын байдлаар

Үйл ажиллагааны чиглэл	2020 - III
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	39.5
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	9.9
Барилга	7.9
Боловсруулах үйлдвэрлэл	6.8
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	5.5
Боловсрол	4.8
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	3.9
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	3.7
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	2.9
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	2.6
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	2.4
Мэдээлэл, холбоо	2.1
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1.8
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн даатгал	1.7
Уул уурхай, олборлолт	1.4
Урлаг, үзвэр, тоглоом наадам	1.3
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1.1
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	0.3
Усан хангамж; бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0.2
Нийт	100.0

“Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд Covid 19-өөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний нөлөөлөл” тандалт судалгаанд үйл ажиллагаа явуулж байгаа нийт 2402 аж ахуйн нэгж хамрагдсан.

Корона вирусээс урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээ нь судалгаанд хамрагдсан 2402 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд ямар нөлөө үзүүлсэн талаар тодруулахад, 46.3% (1113) нь үйл ажиллагаа хэвийн явагдаж байна, 53.7% (1289) нь хэвийн явагдахгүй байна гэсэн хариулт өгчээ.

Үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа 1113 аж ахуйн нэгжийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар (Хүснэгт 2) харуулбал:

- 289 (26.0%) нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбар,
- 112 (10.1%) нь боловсруулах үйлдвэрлэлийн салбар,
- 96 (8.6%) нь хөдөө аж ахуйн салбар,
- 93 (8.4%) нь барилгын салбар,
- 76 (6.8%) нь хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбар,
- 368 (33.1%) нь зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, боловсрол, тээвэр, агуулах, үл хөдлөх хөрөнгө, мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа, уул уурхай, олборлолт, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн даатгал, мэдээлэл, холбоо, урлаг, үзвэр, тоглоом, цахилгаан, хий, агааржуулалт, ус хангамж, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд байна.


Хүснэгт 2. Үйл ажиллагааны байдал, судалгаанд хамрагдсан ААН-ийн тоогоор, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар

Үйл ажиллагааны чиглэл	Нийт	Хэвийн		Хэвийн бус	
		ААН-н тоо	ААН-ийн тоонд эзлэх хувь	ААН-н тоо	ААН-ийн тоонд эзлэх хувь
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	556	289	52.0	267	48.0
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	219	63	28.8	156	71.2
Боловсруулах үйлдвэрлэл	218	112	51.4	106	48.6
Боловсрол	205	48	23.4	157	76.6
Барилга	198	93	47.0	105	53.0
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	161	96	59.6	65	40.4
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	141	79	56.0	62	44.0
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	117	47	40.2	70	59.8
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	115	76	66.1	39	33.9
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	82	53	64.6	29	35.4
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	76	38	50.0	38	50.0
Аялал жуулчлал	73	6	8.2	67	91.8
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн	72	35	48.6	37	51.4
Урлаг, үзвэр, тоглоом	39	9	23.1	30	76.9
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	32	15	46.9	17	53.1
Уул уурхай, олборлолт	31	16	51.6	15	48.4
Мэдээлэл, холбоо	29	11	37.9	18	62.1
Цахилгаан, хий, агааржуулалт	15	8	53.3	7	46.7
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн даатгал	14	12	85.7	2	14.3
Ус хангамж: Сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах, хүрээлэн буй орчныг дахин сэргээх	9	7	77.8	2	22.2
Нийт	2402	1113	46.3	1289	53.7

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзвэл, судалгаанд оролцсон бөөний болон жижиглэн худалдааны үйл ажиллагаа эрхэлдэг 556 ААН-ийн 48.0 хувийнх нь үйл ажиллагаа хэвийн бус байна гэж хариулжээ. Үйл ажиллагаа нь хэвийн бус гэсэн хариултыг:

- зочид буудал, зоогийн газрын үйл ажиллагаа эрхэлдэг 219 ААН-ийн 71.2 хувь,
- боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг 218 ААН-ийн 48.6 хувь,
- боловсролын үйл ажиллагаа эрхэлдэг 205 байгууллагын 76.6 хувь,
- барилгын салбарын үйл ажиллагаа эрхэлдэг 198 ААН-ийн 53 хувь,
- хөдөө аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг 161 ААН-ийн 40.4 хувь нь өгсөн байна.

Зураг 1. Үйл ажиллагаа хэвийн явагдахгүй байгаа аж ахуйн нэгж, салбараар



Судалгаанд “Үйл ажиллагаа хэвийн явагдахгүй байгаа” гэсэн хариулт өгсөн нийт 1289 аж ахуйн нэгжийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар харуулбал:

- 267 (20.7%) нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбар,
- 157 (12.2%) нь боловсролын салбар,
- 156 (12.1%) нь зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбар,
- 106 (8.2%) нь боловсруулах үйлдвэрлэлийн салбар,
- 105 (8.1%) нь барилгын салбар,
- Үлдсэн хувь нь хөдөө аж ахуй, уул уурхай, цахилгаан, хий, агааржуулалт, тээвэр, агуулах, мэдээлэл, холбоо, санхүүгийн болон даатгал, үл хөдлөх хөрөнгө, мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх, аялал жуулчлал, эрүүл мэнд, нийгмийн халамж, урлаг, үзвэр, тоглоом, төрийн удирдлага, батлан хамгаалах, үйлчилгээний зэрэг үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд байна.


СУДАЛГААНЫ ҮР ДҮН

1. Хүчин чадал ашиглалт

Судалгаанд хамрагдсан 2402 аж ахуйн нэгжийн 690 (28.7%) нь бүрэн хүчин чадлаараа ажиллаж байгаа бол 1712 (71.3%) буюу дийлэнх нь бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй байна гэсэн хариулт өгсөн байна.

Салбараар авч үзвэл, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй байна гэсэн 1712 аж ахуйн нэгжийн 22.4 хувь буюу хамгийн өндөр хувийг эзэлж байна.

Зураг 2. Бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй байгаа аж ахуйн нэгжийн тоо, хүчин чадал ашиглалтын хувиар, голлох 5 салбараар



Хүчин чадал ашиглалтыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл, боловсрол, зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээний аж ахуйн нэгжүүдийн дийлэнх нь хүчин чадлынхаа 25 хүртэл хувийг, боловсруулах үйлдвэрлэл, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний аж ахуйн нэгжүүдийн дийлэнх нь хүчин чадлынхаа 26-50 хувийг ашиглаж байна гэж хариулжээ.

Үйл ажиллагаа нь бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй байна гэж хариулсан 1712 аж ахуйн нэгжээс хүчин чадал ашиглалтыг тодруулж асуухад, 735 (42.9%) нь хүчин чадлын 25 хувь, 551 (32.2%) нь хүчин чадлын 26-50 хувь, 426 (24.9%) нь хүчин чадлын 51-75 хувийг ашиглаж байна гэсэн хариултыг тус тус өгсөн байна. Эндээс бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй байгаа 1712 аж ахуйн нэгжийн 75.1 хувь нь хүчин чадлынхаа 50-иас доош хувийг ашиглаж байна гэсэн үр дүн гарч байна.


Бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй байна гэж хариулт өгсөн 1712 аж ахуйн нэгжийн 10.2 хувь буюу 174 ААН-ийн хүчин чадал ашиглалтад Корона вирусний эсрэг явуулж буй үйл ажиллагаа нөлөөлөөгүй гэж хариулсан байна.

Харин 89.8 хувь буюу 1538 аж ахуйн нэгжид Корона вирусний эсрэг явуулж буй үйл ажиллагаа нөлөөлсөн гэжээ.

2. Урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээний нөлөөлөл

Бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй байгаа 1712 аж ахуйн нэгжийн 1538 (89.8%)-д нь урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээ нөлөөлсөн байна.

Зураг 3. Корона вирусээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй байгаа байдалд нөлөөлсөн ААН, салбараар, дүнд эзлэх хувиар



3. ААН-ийн үйл ажиллагаа явуулахад учирч байгаа хүндрэл, бэрхшээл

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн 168 (7.0%) нь Корона вирусээс урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээнээс шалтгаалж, үйл ажиллагаанд нь хүндрэл учраагүй, хэвийн явагдаж байна гэж хариулсан бол 2234 (93.0%) нь үйл ажиллагаа хэвийн явуулахад хүндрэл учирсан гэсэн хариулт өгсөн байна.

Хүснэгт 3. ААН-ийн үйл ажиллагаа явуулахад учирч байгаа хүндрэл, бэрхшээл шалтгаанаар

Шалтгаан (олон сонголттой)	Аж ахуйн нэгжийн тоо	Дүнд эзлэх хувь
Санхүүгийн байдал хүндэрсэн	1157	48.2
Үйлчлүүлэгчийн тоо эрс буурсан	1079	44.9
Ажиллагчдынхаа цалинг олгох, НДШ-ийг төлөхөд хүндрэлтэй болсон	668	27.8
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, бусад татвар, хураамжийг төлөхөд хүндрэлтэй болсон	580	24.1
Зээл, зээлийн хүү төлөхөд хүндрэлтэй болсон	571	23.8
Корона вирусээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хөл хорио тавигдтал үйл ажиллагаагаа түр зогсоосон	528	22.0
Үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ эрс буурсан	464	19.3
Бусад төлбөр төлөхөд хүндрэлтэй болсон (ус, цахилгаан, дулаан гэх мэт)	376	15.7
Төлөвлөсөн хөрөнгө оруулалт хийгдээгүй, хойшлогдсон	324	13.5
Түүхий эд, материал, барааны татан авалт удааширсан	307	12.8
Түрээсийн төлбөрөө төлөхөд хүндрэлтэй болсон	307	12.8
Бусад	304	12.7
Түүхий эд, бараа, үйлчилгээний эрэлт эрс буурсан	299	12.4
Түүхий эд, материал, барааны нөөц багассан	290	12.1
Түүхий эд, материал, барааны татан авалт зогссон	277	11.5
Ажиллагчдын тоог бууруулсан	227	9.5
Түүхий эд, материал, барааны хомсдол үүсэж, дууссан	143	6.0
Түүхий эд, материал, бараа, үйлчилгээг цаг хугацаанд нь хүргэж чадахгүй болсон	132	5.5

Тайлбар: Олон сонголттой хариултаас хамгийн их давтагдсанаар нь эрэмбэлсэн

4. Орлого буурахад үзүүлж байгаа нөлөө

Корона вирусээс урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээнээс шалтгаалж, орлого нь буурсан эсэхийг тодруулахад, судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн 2036 (84.8%) нь орлого буурсан, 366 (15.2%) нь орлого буурах нөлөө үзүүлээгүй гэсэн хариулт өгсөн байна.

Зураг 4. Орлого буурсан аж ахуйн нэгж, орлогын бүлгээр, дүнд эзлэх хувь




Орлого буурсан гэж хариулсан 2036 аж ахуйн нэгжээс орлогын бууралтыг хувиар тодруулахад, 889 нь орлого нь 50-иас дээш хувь, 322 нь 41-50 хүртэл хувь, 276 нь 31-40 хүртэл хувь, 260 нь 21-30 хүртэл хувь, 166 нь 11-20 хүртэл хувь, 123 нь 10 хүртэл хувиар орлого буурсан гэсэн хариулт өгсөн байна.

Корона вирусээс урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээнээс шалтгаалан орлого буурсан гэж хариулсан аж ахуйн нэгжүүдийг салбараар харуулбал,

- 475 (23.3%) нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ
- 192 (9.4%) нь боловсруулах үйлдвэрлэлийн салбар
- 185 (9.1%) нь зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбар,
- 170 (8.3%) нь боловсролын салбар,
- 167 (8.2%) нь барилгын салбар
- Үлдсэн хувь нь бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд байна.

Зураг 5. Корона вирусээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнээс шалтгаалан орлого буурсан аж ахуйн нэгж, салбараар



Хүснэгт 4. Орлого буурсан аж ахуйн нэгжийн тоо, дүнд эзлэх хувиар, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар

Үйл ажиллагааны чиглэл	Аж ахуйн нэгжийн тоо	Дүнд эзлэх хувь
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	475	23.3
Боловсруулах үйлдвэрлэл	192	9.4
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	185	9.1
Боловсрол	170	8.3
Барилга	167	8.2
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	144	7.1
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	118	5.8
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	97	4.8
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	96	4.7
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	72	3.5
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	66	3.2
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	63	3.1
Аялал жуулчлал	51	2.5
Урлаг, үзвэр, тоглоом	32	1.6
Уул уурхай, олборлолт	29	1.4
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	28	1.4
Мэдээлэл, холбоо	18	0.9
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн даатгал	13	0.6
Цахилгаан, хий, агааржуулалт	12	0.6
Ус хангамж: сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	8	0.4
Нийт	2036	100.0

6. Корона вирусээс урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээнээс шалтгаалж аж ахуйн нэгжээс дотооддоо авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдээс 860 нь Засгийн газар, Улсын онцгой комиссоос гаргасан шийдвэрийн дагуу ажиллагчдадаа цалинтай чөлөө олгож, гэрээсээ ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байна. Харин 1542 аж ахуйн нэгж ямар нэг арга хэмжээ аваагүй байна.

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн 638 нь ажиллагчдадаа цалинтай чөлөө олгосон бол 1764 нь ажиллагчдадаа цалинтай чөлөө олгоогүй гэсэн хариулт өгсөн байна.

7. Корона вирусээс урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээтэй холбоотойгоор ажиллагчдадаа зайнаас ажиллах боломж олгосон байдал

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжээс 295 нь урд өмнө нь зайнаас ажиллах нөхцөлийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байсан бол дийлэнх буюу 2107 нь зайнаас ажиллах нөхцөлийг хэрэгжүүлж байсан туршлагагүй гэж хариулсан байна.

Хүснэгт 5. Гэрээсээ ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байдал

	ААН-н тоо	Дүнд эзлэх хувь
Зайнаас ажиллах нөхцөл бүрдүүлж, боломж олгосон	814	33.9
Зайнаас ажиллах нөхцөл бүрдүүлээгүй, боломж олгоогүй	1588	66.1
Бүгд	2402	100.0

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн 814 (33.9%) нь зайнаас (гэрээсээ) ажиллах нөхцөлийг бүрдүүлж, боломж олгосон бол 1588 (66.1%) нь буюу дийлэнх нь энэ нөхцөлийг бүрдүүлээгүй, боломж олгоогүй гэж хариулсан байна

Зайнаас ажиллах нөхцөл бүрдүүлж, боломж олгосон 814 аж ахуйн нэгжээс ашигласан арга, хэлбэрийн талаар тодруулахад, 588 нь интернэт ашигласан, 166 нь хэрэгцээтэй ажлын файл, материалыг авч явсан, 121 нь тоног төхөөрөмжөөр хангаж өгсөн, 81 нь тусгайлсан онлайн сүлжээ бий болгосон, 171 нь бусад гэсэн хариултыг тус тус өгсөн байна.

Зураг 6. Зайнаас ажиллах нөхцөл бүрдүүлж, боломж олгосон ААН-ийн ашигласан арга, хэлбэр, аж ахуйн нэгжийн тоогоор



8. Зээл, зээлийн хүүгийн төлөлтийн хугацааг хойшлуулах шийдвэрт хамрагдсан байдал

Зураг 7. Зээл, зээлийн хүүгийн төлөлтийн хугацааг хойшлуулах шийдвэрт хамрагдсан байдал

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн 360 (15.0%) нь зээл, зээлийн хүүгийн төлөлтийн хугацааг хойшлуулах шийдвэрт хамрагдсан байна.

Харин 2042 (85.0%) аж ахуйн нэгж “зээл, зээлийн хүүгийн төлөлтийн хугацааг хойшлуулах” шийдвэрт хамрагдаагүй гэсэн хариулт өгсөн байна.



9. Үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардагдах хугацаа

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжээс корона вирусээс урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээ тавигдсанаас хойш үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардагдах хугацааны талаар тодруулсан.

Хүснэгт 6. Үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардагдах хугацаа, аж ахуйн нэгжийн тоогоор, дүнд эзлэх хувь

Хугацаа	Аж ахуйн нэгжийн тоо	Дүнд эзлэх хувь
3 сар хүртэл	631	26.3
3-6 сар хүртэл	442	18.4
6-12 сар хүртэл	341	14.2
1 жилээс дээш	151	6.3
Тодорхойгүй	837	34.8
Бүгд	2402	100.0

Нийт ААН-ийн 631 (26.3%) нь 3 сар хүртэл, 442 (18.4%) нь 3-6 сар хүртэл, 341 (14.2%) нь 6-12 сар хүртэл, 151 (6.3%) нь 1 жилээс дээш хугацаа шаардагдана гэж хариулсан байна.

Харин 837 (34.8%) нь үйл ажиллагаагаа хэвийн явуулж эхлэх хугацаа тодорхойгүй гэж хариулсан байна.

10. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн корона вирусээс урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээний аж ахуйн нэгжүүдэд өгсөн сургамж, нөлөө

Корона вирусний (Covid-19) тархалт дэлхийн бүх улс орнуудыг хамарч, шинээр дэгдэж байгаа шинэ төрлийн халдвар учраас энэ нь дэлхийн улс орнуудад олон төрлийн сургамж, нөлөөг үзүүлсээр байгаа юм.

Корона вирусээс урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээ нь аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж, ямар сургамжийг өгсөн талаар тодруулж асуусан.

Судалгаанд оролцсон нийт аж ахуйн нэгжийн дийлэнх нь дараах 5 төрлийн сургамж, нөлөөг нэрлэсэн байна. Тухайлбал:

- Ажлын байрны ариун цэврийн стандарт, хамгаалалт хадгалалтыг сахиж, хамгаалах хэрэгслийг нөөцлөх, хангах, мөрдөх, сайжруулахад нөлөө үзүүлсэн
- Зайлшгүй тохиолдолд эрсдэлээс хамгаалах хуримтлалтай байх сургамж өгсөн
- Мэдээллийн бодит эх үүсвэрийг ашиглах сургамж өгсөн
- Эрсдэл тохиолдсон нөхцөлд түүхий эд, материал, барааны нөөцийг бэлтгэх сургамж өгсөн
- Эрсдэлээс хамгаалах байгууллагын стратеги, бодлого, журамтай байх сургамж өгсөн

Хүснэгт 7. Корона вирусээс урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээний аж ахуйн нэгжүүдэд өгсөн сургамж, нөлөө, аж ахуйн нэгжийн тоо, төрлөөр

	ААН-ийн тоо	Дүнд эзлэх хувь
Ажлын байрны ариун цэврийн стандарт, хамгаалалт хадгалалтыг сахиж, хамгаалах хэрэгслийг нөөцлөх, хангах, мөрдөх, сайжруулахад нөлөө үзүүлсэн	1187	49.4
Зайлшгүй тохиолдолд эрсдэлээс хамгаалах хуримтлалтай байх сургамж өгсөн	871	36.3
Мэдээллийн бодит эх үүсвэрийг ашиглах сургамж өгсөн	627	26.1
Эрсдэл тохиолдсон нөхцөлд түүхий эд, материал, барааны нөөцийг бэлтгэх сургамж өгсөн	583	24.3
Эрсдэлээс хамгаалах байгууллагын стратеги, бодлого, журамтай байх сургамж өгсөн	565	23.5
Зарим тохиолдолд зайнаас (гэрээс) үйл ажиллагаагаа явуулах боломжтойг тогтоосон	435	18.1
Онлайн худалдаа, хүргэлтийн худалдааг хөгжүүлэх сэдэл, боломжийг олгож, нэмэгдүүлэхэд нөлөө үзүүлсэн	280	11.7

Тайлбар: Олон сонголттой хариултаас хамгийн их давтагдсанаар нь эрэмбэлсэн

11. Корона вирусээс урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээтэй холбоотой төр засгаас авч, хэрэгжүүлэх арга хэмжээ

Корона вирусээс урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээтэй уялдуулан цаашид төр засгаас дараах чиглэлийн шийдвэрийг гаргаж, хэрэгжүүлэхийг судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүд санал болгосон. Тухайлбал, хамгийн олон давтагдсан саналыг танилцуулбал:

- Татварын хөнгөлөлт үзүүлэх, татвар төлөлтийг тодорхой хугацаагаар хойшлуулах,
- Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн хугацааг хойшлуулах
- Үйл ажиллагааны зардалд тодорхой хэмжээний хөнгөлөлт үзүүлэх
- Зээл авах боломжийг бий болгох бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Зээл, зээлийн хүүгийн төлөлтийн хугацааг хойшлуулах

Хүснэгт 8. Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал, төрлөөр (олон сонголттой)

Саналын агуулга	Аж ахуйн нэгжийн тоо	Дүнд эзлэх хувь
Татварын хөнгөлөлт үзүүлэх, тодорхой хугацаагаар хойшлуулах	1368	57.0
НДШ төлөлтийг хугацааг хойшлуулах	1239	51.6
Үйл ажиллагааны зардалд тодорхой хэмжээний хөнгөлөлт үзүүлэх	1035	43.1
Зээл авах боломжийг бий болгох бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлэх	933	38.8
Зээл, зээлийн хүүгийн төлөлтийн хугацааг хойшлуулах	903	37.6
Эдийн засгийг богино хугацаанд сэргээх, эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хангах үүднээс бодлогын хүүг бууруулах	875	36.4
Үйл ажиллагааг сэргээхэд гарах асуудлуудыг төрийн бодлогоор шуурхай шийдэхэд дэмжлэг үзүүлэх	743	30.9
Эрсдэл, гамшгийн үед аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, эдийн засагт учирч болзошгүй аюулаас сэргийлэх, даван туулах стратеги боловсруулах	678	28.2

Судалгаанд хамрагдсан 119 аж ахуйн нэгж, дээрх ангилалд ороогүй нэмэлт саналуудыг өгснийг хамгийн их давтагдсанаар нь эрэмбэлбэл,

- Жижиг, дунд үйлдвэр болон аж ахуйн нэгжүүдээ дэмжих, бага хүүтэй зээл олгох
- Урт хугацаатай, хүү багатай зээл тусламж олгох
- Банкны зээлийн хүүг бууруулах
- Хөл хориог яаралтай цуцлах
- Аж ахуйн нэгж, байгууллагын 200 мянган төгрөгийг олгох
- Сургалтын төвүүдийг нээх гэх мэт саналуудыг өгсөн байна.

Төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Монгол Улсын Засгийн газраас 3-р сарын 27-нд бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр арга хэмжээ авч, дараах шийдвэрүүдийг гаргасан. Үүнд:

- 4-р сарын 1-нээс 10-р сарын 1 хүртэлх хугацааны ААНБ-уудын НДШ-ийг бүрэн тэглэсэн. Хувиараа нийгмийн даатгал төлдөг иргэдэд мөн адил үйлчилнэ.
- 4-р сарын 1-нээс 10-р сарын 1 хүртэлх 6 сарын хугацаанд иргэдийн цалингаас орлогын албан татвар авахгүй, бүрэн чөлөөлнө.
- 4-р сарын 1-нээс 10-р сарын 1 хүртэл 1.5 тэрбум төгрөгөөс доош орлоготой ААНБ-уудаас орлогын татвар авахгүй.
- Үйл ажиллагаа нь хүндэрсэн ч ажлын байраа хадгалж байгаа ААНБ-уудын ажилтнуудад сар бүр 200 000 төгрөгийг дэмжлэг олгоно. Энэ үйл ажиллагаа 3 сар үргэлжилнэ.
- Малчдын амьжиргааг дэмжих зорилгоор малчдад 3 хувийн хүүтэй 300 тэрбум төгрөгийн зээл олгоно. Зээлийн зөрүүг Засгийн газар хариуцна.
- 18 насны хүүхэд бүрт олгодог мөнгийг гурван сарын хугацаанд сар бүр 10 000 төгрөгөөр нэмэгдүүлж, 30 000 төгрөг болгож байна.
- Шатахууны үнийг 4-р сарын 15-наас литр тутамд 300-400 төгрөгөөр бууруулна.

Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулж 5.1 их наяд төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн.

Мөн Монгол Улсын Засгийн газар 5-р сарын 6-ны өдрийн 167 дугаар тогтоолоор цар тахлын үед эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн амьжиргааг дэмжих, нийгмийн хамгааллын чиглэлээр зарим арга хэмжээг авсан. Үүнд:

- Малчдын орлогыг нэмэгдүүлэх, үндэсний үйлдвэрүүдийг дэмжих зорилгоор 2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүнд үндэслэн, ноолуурын хэмжээг “Монгол ямааны үүлдэр, омог. Ерөнхий шаардлага” (MNS 0550:2011) стандартаар тооцож, 1 кг тутамд 20 000 төгрөгийн урамшуулал олгох;
- 5-р сарын 1-нээс 10-р сарын 1 хүртэл Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлж, сар бүр 288 000 төгрөг олгох;
- 4-р сарын 1-нээс 10-р сарын 1 хүртэл 18 хүртэлх насны хүүхэд бүрт олгож байгаа хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нэмэгдүүлж сар бүр 100 000 төгрөг олгох зэрэг арга хэмжээнүүдийг авсан.